



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН
*нөхөн үржихүйн эрүүл
мэнд*

Улаанбаатар

2018 он

Эмэгтэйчүүд дэлхий дахинд

Дэлхий дахинд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 62 саяар илүү байгаагаас 60, түүнээс дээш насны хүн амын 54 хувь, 80-аас дээш насны хүн амын 62 хувь нь эмэгтэйчүүд байна.

Сүүлийн 20 жилийн хугацаанд боловсролын түвшнийг нэмэгдүүлж, дараа нь ажиллах хүчинд орох, эдийн засгийн бие даасан байдал сайжруулах зэргээс улбаалан гэрлэлтийн хэв маяг өөрчлөгдөн, гэрлэлтийн нас хойшлох хандлагатай байна. Тухайлбал, эмэгтэйчүүдийн гэрлэлтийн дундаж нас 25, эрэгтэйчүүдийн хувьд 29 байна.

Дэлхий нийтээр 2010-2015 оны байдлаар нэг эмэгтэй амьдралынхаа хугацаанд 2-3 хүүхэд төрүүлж байгаа нь 1990-1995 оны түвшнээс гурваар буурчээ. Гэхдээ төрөлтийн түвшний өөрчлөлт нь улс орнуудад харилцан адилгүй байгаа юм[1].

Дэлхий даяар 2010-2014 оны хооронд жилд дунджаар 56 сая эмэгтэйчүүд үр хөндүүлсэн байгаагаас нөхөн үржихүйн эрүүл мэндийн насны буюу 15-44 насны 1000 эмэгтэй тутамд 35 эмэгтэй үр хөндүүлсэн гэсэн тооцоо байна.

Улс орны хөгжлийн түвшнээс хамаарч хөгжиж буй орнууд хөгжингүй орнуудаас үр хөндөлт хийлгэх магадлал өндөр, тухайлбал үр хөндөлтийн түвшин хөгжиж буй орнуудад 36 байгаа бол хөгжингүй оронд 27 байна. Үр хөндөлтийн түвшин хөгжингүй орнуудад 1990-1994, 2010-2014 оны хооронд 46-аас 27 болж буурсан бол, хөгжиж байгаа улсуудад хэвээр ажээ.

Хөгжиж буй улсуудын үр хөндөлтийн тохиолдол 1990-1994 онд нийт үр хөндөлтийн 76 хувийг эзлэж байсан бол 2010-2014 онд 88 хувь болж өссөн байна¹.

Монгол улсын хувьд эмэгтэйчүүдийн дунд үр хөндөлтийн түвшин 2011-2014 онд дунджаар 19.9 байгаа нь дэлхийн дундаж болон хөгжиж буй улсуудын дундаж түвшнээс бага байна.


¹ <https://www.who.int/reproductivehealth/news/abortion-rates/en/>

Монголын эмэгтэйчүүдийн тухай

Монгол Улсын хүн амын төрөлтийн түвшин өндөр, залуу насны бүтэцтэй байх 1969-1980 оны дунд үе хүртэл дунджаар хүн амын 21 хувь буюу 5 хүн тутмын нэг нь нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд байсан бол энэ нь 1990-ээд оноос хойш өсөж, дунджаар 30 хувь болжээ. Тухайлбал, 2017 онд хүн ам 3.2 сая байгаагаас 1.6 сая (50.8%) нь эмэгтэйчүүд, тэдгээрийн 54 хувийг нөхөн үржихүйн буюу 15-49 насны эмэгтэйчүүд эзэлж байна. Өөрөөр хэлбэл, 3 хүн тутмын нэг нь нөхөн үржихүйн насны эмэгтэй байна /27.2%/.

Төрөх насны эмэгтэйчүүдийн нийт хүн амд эзлэх хувь нэмэгдсэн хэдий ч төрүүлэх хүүхдийн тоо буурч байгаад нийгэм, эдийн засаг, амьдралын хэв маягийн өөрчлөлт, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байна. Тухайлбал, Хүн ам, орон сууцны 1979 оны тооллогоор анхны гэрлэлтийн дундаж нас эмэгтэйчүүдэд 22, эрэгтэйчүүдэд 20 байснаа 2010 оны тооллогоор эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль аль нь 5 жилээр хойшилжээ. Түүнчлэн 1979 оны тооллогоор нийт эмэгтэйчүүдэд эзлэх дээд боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь 4.2 байснаа 2010 оны тооллогоор 22.7 болж нэмэгдсэн байна.

Зураг 1. Төрөлтийн нийлбэр коэффициент(ТНК), 1975-2017 он



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Монгол эмэгтэйчүүд дунд нөхөн үржихүйн насны нэг эмэгтэйн амьдралынхаа хугацаанд төрүүлсэн хүүхдийн тоо (төрөлтийн нийлбэр коэффициент) 1975 онд 7 байснаа 1995 он хүртэл 5 жил тутамд 1-ээр буурч 3 болсон байна. Харин

1995-2005 онд энэ тоо аажим буурч 2 орчим байснаа, 2005 оноос аажмаар нэмэгдсээр, 2015 онд 3 болж, 2017 он хүртэл энэ хэмжээндээ тогтворжсон байна.

Монгол Улс төрөлтийг дэмжих бодлого баримтлан эхчүүдийг төрүүлсэн хүүхдүүдийн тооноос нь хамааруулан, тухайлбал, 6, түүнээс дээш хүүхэдтэй эхэд “Алдарт эхийн I” одон, 4-5 хүүхэдтэй эхэд “Алдарт эхийн II” одон олгодог системтэй. Одон авсан эхчүүдийн тоог харвал, 2010 онд 125.6 мянга байснаа 2017 онд 214.7 мянга болж, 71 хувиар өссөн байна. Үүнд “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай” хуульд 2011 оноос эхлэн 6, түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг I зэргийн, 4 хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг II зэргийн одонгоор шагнахаар нэмэлт өөрчлөлт оруулсан мөн нөлөөлсөн.

Хүснэгт 1. Алдарт эхийн одонтой эхчүүдийн тоо, 2010-2017 он

Он	Одонтой эхчүүд, бүгд	Үүнээс: одонгийн төрлөөр		15, түүнээс дээш насны эмэгтэйчүүдэд эзлэх одонтой эхчүүдийн хувь
		I одон	II одон	
2010	125,556	33,600	91,956	8.8
2011	204,313	63,530	140,783	13.1
2012	189,912	74,982	114,930	10.5
2013	202,474	86,225	116,249	10.5
2014	207,668	75,567	132,101	11.8
2015	208,670	73,680	134,990	12.1
2016	210,628	72,266	138,362	12.3
2017	214,744	70,822	143,922	12.6

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Эмэгтэйчүүд амьдралынхаа хугацаанд хэдэн удаа төрөх нь тухайн хүний болон гэр бүлийн амьдралаас шалтгаалах сонголт бөгөөд үүнийг зохицуулах гол арга нь гэр бүл төлөвлөлт, жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн үйлчилгээ юм. “Гэр бүл төлөвлөлт” нь тухайн эмэгтэй болон хосууд хүссэн тооныхоо хүүхдийг төлөвлөж төрүүлэх, төрөлт хоорондын хугацааг зохицуулах боломжийг олгох бөгөөд үүнийг жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн үйлчилгээгээр дамжуулан хэрэгжүүлдэг².

² “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2013”, УСХ, 2014 он

Монгол Улсын төрөөс гэр бүл төлөвлөлт/ГБТ/-ийн талаар баримталж байсан бодлогыг авч үзэхэд 1990-ээд он хүртэл ГБТ нь хүний эрхийн асуудал хэмээн хүлээн зөвшөөрсөн боловч түүнийг хэрэгжүүлэх үйлчилгээг эрүүл мэндийн үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг болгохыг дэмждэггүй, жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслээс зөвхөн умайн ерөндгийг эмч нарын зөвлөгөөний шийдвэрээр архаг өвчтэй эсвэл эмнэлгийн заалттай эмэгтэйчүүдэд хэрэглэдэг, нөгөө талаасаа үр хөндөлтийг хуулийн хүрээнд хязгаарласан байв. Харин 1990-ээд оноос хойш МУ-ын Засгийн газар НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр нөхөн үржихүйн эрүүл мэндийн 5 жилийн хугацаатай 4 удаагийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, ГБТ-ийг хэрэгжүүлсэн байна. Түүнчлэн 1989 оноос үр хөндөлтийг хуулийн хүрээнд зөвшөөрснөөр мэргэжлийн зөвшөөрөлтэй эмнэлгийн мэргэжилтэн хууль, журамд заасны дагуу үйлчилгээ үзүүлдэг болжээ. Гэхдээ энд нэг ялгаатай зүйл нь төрийн өмчийн эмнэлэгт зөвхөн эмчийн заалттай тохиолдолд үр хөндөлтийг хийдэг бол хувийн эмнэлэгт үйлчлүүлэгчдийн хүсэлтийг харгалзан төлбөртэй үйлчилдэг байна³.

Үр хөндөлтийн байдал


Эрүүл мэндийн яамны мэдээгээр үр хөндөлтийн харьцаа буюу 1000 амьд төрөлтөд ногдох үр хөндөлт 1990-1993 онд хамгийн өндөр 405-445 байсан бол 2017 онд 233 болж, бараг 2 дахин буурчээ. Харин энэ хугацаанд 15-49 насны нөхөн үржихүйн эмэгтэйчүүдийн нийт эмэгтэйчүүдэд эзлэх хувь багахан хэмжээний тогтвортой өсөлттэй байна.

Энгийнээр тайлбарлавал, 1990-1993 онд 3 жирэмслэлт тутмын 2 нь төрөлтөөр, 1 нь үр хөндөлтөөр төгсөж байсан бол 2017 онд 5 жирэмслэлт тутмын 4 нь төрөлтөөр, 1 нь үр хөндөлтөөр төгссөн байна.

Эрүүл мэндийн яамны мэдээг ашиглан тооцсон үр хөндөлтийн харьцааг 2003, 2008 оны нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа болон 2013 оны нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны дүнтэй харьцуулбал, хандлага ижил байна.

³ "Монгол Улс дахь гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний нөхцөл байдлын дүн шинжилгээ", ЭМЯ, НҮБХАС, 2016 он

Зураг 2. Үр хөндөлтийн харьцаа, нийт эмэгтэйчүүдэд 15-49 насныхны эзлэх хувь




Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, Эрүүл мэндийн яам

Тайлбар: 2003, 2008 оны Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгааны дүн, 2013 оны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны дүн

Үр хөндөлтийг 1998-2017 оны мэдээллээс илүү нарийвчлан насны бүлгээр авч үзвэл, ойролцоогоор үр хөндүүлсэн 10 эмэгтэй тутмын 7 (65-75 хувь) нь 20-34 насны, 2 нь 35, түүнээс дээш насны, 1 нь 20 хүртэлх насны эмэгтэйчүүд байна.

Зураг 3. Үр хөндүүлсэн эмэгтэйчүүд, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 1998-2017 он




Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

Үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн дотор (1998-2017 онд) тодорхой ажил эрхэлдэг эмэгтэйчүүд болон ажилгүй, гэрийн ажилтай гэсэн эмэгтэйчүүд ойролцоогоор 80 гаруй хувийг, оюутан, болон малчин эмэгтэйчүүд 20 орчим хувийг эзэлж

байна. 1998-2012 онд ажилгүй болон гэрийн ажилтай эмэгтэйчүүд ажилтай эмэгтэйчүүдээс илүү байснаа, 2012 оноос хойш эсрэг хандлагатай болсон байна. Харин үр хөндүүлсэн малчин эмэгтэйчүүдийн эзлэх хувь тасралтгүй буурах хандлагатай болжээ.

Зураг 4. Үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн нийгмийн байдал, дүнд эзлэх хувиар, 1998-2017 он



Тайлбар: *- ажилгүй, гэрийн ажилтай, бусад гэсэн эмэгтэйчүүдийг хамруулав

Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

Түүнчлэн үр хөндүүлсэн эмэгтэйчүүдэд төрөөгүй эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2000 онд 9.2 байснаа 2014 он хүртэл аажмаар буурч 2.7, түүнээс хойш эргээд нэмэгдэн 4.4 хувьд хүрсэн байна. Харин жирэмсний хугацааны хувьд хожуу үр хөндөлт⁴ хийлгэсэн хандлага хэлбэлзэлтэй, энэ нь дунджаар нийт үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 12.5 хувь байна /Хавсралт 1/.

Үр хөндөлтийн дараа гарсан хүндрэл 1998-2012 онд 7.2 хувиас 0.6 хувь болж, тасралтгүй буурснаа, 2012 онд 1.8 хувь болон өссөн бол түүнээс хойш 0.1 хувьд хүрч, буурах хандлагатай байна /Хавсралт 1/.

Бүсээр авч үзвэл, үр хөндөлт өндөр 1990-1993 оны дунджаар нийт үр хөндөлтийн 48.4 хувь нь Улаанбаатарт, 18.3 хувь нь Хангай бүс, 17.1 хувь нь төвийн бүсэд ногдож байснаа 2017 оны байдлаар Улаанбаатарт дийлэнх нь буюу 72.2 хувь, Хангайн бүсэд 8.8, Төвийн бүсэд 9.1 хувь болж өөрчлөгдсөн байна.

⁴ “Хожуу үеийн үр хөндөлт” гэж жирэмсний арван гурван долоо хоногоос хорин хоёр долоо хоногийн дотор жирэмсэлтийг эмнэлгийн аргаар таслах ажилбарыг хэлнэ. Үр хөндөлтийг зохицуулах журам,

Аймгийн түвшинд 1991 онд нийт үр хөндөлтөд эзлэх хувь хамгийн өндөр 4 аймагт Дархан-Уул (7.3%), Орхон (6.2%), Хөвсгөл (4.0%), Дорнод (3.9%) байсан бол 2017 оны байдлаар Орхон (3.6%), Увс (3.5%), Өмнөговь(3.5%), Баянхонгор (2.4%) аймгууд тус тус орж байна /Хавсралт 2/.

Товч дүгнэлт

Сүүлийн 28 жилийн хугацаанд үр хөндөлтийн харьцаа 1990-1993 онд хамгийн өндөр 405-445 байснаа 2017 онд 233 болж ойролцоогоор 2 дахин буурчээ. Ийнхүү үр хөндөлт буурахад голлон нөлөөлсөн зүйл нь нэг талдаа жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэлийн мэдлэг, хэрэглээ нэмэгдсэнтэй, нөгөө талдаа өрх, гэр бүлийн эдийн засагт 1990-ээд онтой харьцуулахад ахиц гарч, эмэгтэйчүүд хүүхэд төрүүлэх нь нэмэгдсэнтэй холбоотой юм.

Эцэст нь дүгнэхэд, эрүүл мэндийн яамны мэдээгээр үр хөндөлтийн ерөнхий хандлага гарч байгаа хэдий ч хувийн эмнэлгүүдийн бүртгэл хэр байгаад анхаарал хандуулах чухал шаардлагатай юм. Түүнчлэн эмнэлгийн заалттайн улмаас /өсөлтгүй жирэмслэлт, эрүүл мэндийн шалтгаан зэрэг/ болон өөрөө хүссэн тохиолдлыг зааглан, давтан үр хөндөлтийн шалтгаан, нөхцөл байдал зэргийг нарийвчлан судалж, холбогдох бодлого, хөтөлбөрт оновчтой тусгах нь зүйтэй.

ХАВСРАЛТ 1. Үр хөндүүлсэн эмэгтэйчүүд, сонгосон үзүүлэлтээр, 1998-2017 он

Үзүүлэлтүүд		1998	2000	2002	2004	2006	2008	2010	2012	2014	2015	2016	2017
Бүгд		9,135	11,837	9,977	8,919	12,594	10,688	12,492	18,473	18,145	18,168	18,316	17,530
Хожуу үр хөндөлт		-	1,178	667	545	462	386	442	511	497	510	606	778
Насны бүлэг	20 хүртэлх насны	506	901	675	682	-	-	-	-	-	-	-	-
	20-34 насны	5,999	7,983	6,580	5,853	-	-	-	-	-	-	-	-
	35, түүнээс дээш насны	2,630	2,953	2,722	2,384	-	-	-	-	-	-	-	-
	15-19 насны	-	-	-	-	737	764	746	978	1,202	935	919	921
	20-24 насны	-	-	-	-	2,551	2,365	3,579	5,178	3,798	3,356	3,309	2,950
	25-29 насны	-	-	-	-	3,211	2,499	3,048	4,915	4,947	5,126	5,227	4,918
	30-34 насны	-	-	-	-	3,126	2,319	2,465	3,768	3,887	4,219	4,407	4,408
	35-39 насны	-	-	-	-	1,940	1,853	1,803	2,401	2,939	3,040	3,073	2,815
	40-44 насны	-	-	-	-	897	804	763	1,053	1,267	1,379	1,273	1,375
	45-49 насны	-	-	-	-	131	84	88	179	103	113	106	139
59, түүнээс дээш	-	-	-	-	1	-	-	1	2	-	2	4	
Нийгмийн байдал	Ажиллагч	3,673	4,187	3,516	2,717	4,624	3,882	4,434	8,073	8,025	8,042	7,988	7,585
	Малчин	1,007	1,159	1,093	783	976	853	688	908	1,054	928	771	955
	Оюутан	914	1,712	1,319	1,133	2,031	1,558	2,282	3,529	2,655	1,983	2,137	1,786
	Бусад*	3,541	4,779	4,049	4,286	4,963	4,395	5,088	5,963	6,411	7,215	7,420	7,204
Хэд дэхь жирэмслэлтийн дараа	Төрөөгүй	403	1,086	1,443	1,052	1,497	1,140	1,458	2,860	2,622	2,043	3,305	1,581
	Үүнээс: анхны	-	-	-	-	-	-	-	-	1,844	1,418	1,432	1,372
	2 дахь	-	-	-	-	-	-	-	-	533	341	870	142
	3 дахь	-	-	-	-	-	-	-	-	194	183	756	26
	4, түүнээс дээш	-	-	-	-	-	-	-	-	51	101	247	41
Хэд дэхь төрөлтийн дараа	анхны	1,205	1,824	1,391	1,629	2,111	2,059	2,069	3,105	-	-	-	-
	2 дахь	1,988	2,489	1,909	1,847	2,629	2,277	2,437	3,939	-	-	-	-
	3 дахь	2,112	2,411	1,848	1,762	3,358	2,258	2,311	3,604	-	-	-	-
	4, түүнээс дээш	3,427	4,027	3,386	2,629	2,999	2,954	4,217	4,965	-	-	-	-
	анх	4,908	6,340	6,081	4,724	5,786	5,344	7,053	9,647	6,765	5,310	7,986	8,619
Хэд дэхь төрөлтийн дараа	2 дахь	2,575	2,827	2,430	2,275	3,858	2,818	3,289	5,364	4,489	4,393	5,841	5,293
	3 дахь	1,052	1,502	901	1,176	1,841	1,437	1,380	2,249	2,765	3,303	2,848	2,316
	4 дэхь	353	636	344	480	849	681	529	794	2,770	2,541	1,051	795
	5, түүнээс дээш	247	532	221	264	260	408	241	419	1,356	2,621	590	507
Үр хөндөлтийн дараах хүндрэл	нас барсан	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
	умайн цоорсон	6	5	2	7	6	3	6	2	4	3	2	1
	умайн агшилт	453	69	43	49	38	33	23	25	75	17	12	9
	үжил халдвар	2	9	-	-	-	-	21	-	-	1	-	-
	умайн дайврын үрэвсэл	123	60	77	18	58	56	7	159	54	28	23	9
	бусад	69	13	14	10	3	9	23	154	-	3	4	4

Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

ХАВСРАЛТ 2. Үр хөндөлтийн тоо, аймаг, нийслэл, бүсээр 1989-2017 он

Аймаг	1989	1990	1991	1992	1993	1994	1996	1998	2000	2002	2004	2006	2008	2010	2012	2014	2015	2016	2017	2017/1991
Улсын дүн	16,741	29,635	31,217	28,108	20229	17,025	15,588	9,135	11,837	9,977	8,919	12,594	10,688	12,492	18,473	18,145	18,168	18,316	17,530	0.62
Баруун бүс	1,426	2,594	2,520	2,419	1898	1,593	1,073	900	1,147	1,318	562	547	868	966	515	952	830	742	1,124	0.46
Баян-Өлгий	216	260	189	192	179	227	166	147	358	162	99	34	54	105	34	384	357	331	342	1.78
Говь-Алтай	250	362	334	343	254	250	145	110	237	249	104	100	68	96	111	95	66	31	42	0.12
Завхан	340	765	826	787	564	482	234	133	109	368	71	97	62	72	22	79	65	38	55	0.07
Увс	352	752	657	658	483	247	229	249	294	239	203	253	481	517	191	256	217	211	610	0.93
Ховд	268	455	514	439	418	387	299	261	149	300	85	63	203	176	157	138	125	131	75	0.17
Хангайн бүс	2,673	5,184	5,367	5,328	3979	2,352	1,373	1,441	1,203	1,118	1,053	1,763	854	1,335	2,250	3,267	2,056	1,533	1,544	0.29
Архангай	197	586	685	636	476	332	165	166	90	104	101	114	25	208	155	186	224	212	234	0.37
Баянхонгор	265	606	469	413	146	111	151	102	100	67	64	367	265	153	176	135	30	292	412	1.00
Булган	223	282	283	389	105	63	80	140	89	92	117	46	19	31	26	50	16	13	25	0.06
Өвөрхангай	412	758	745	615	608	496	138	138	159	125	85	403	475	377	776	1,043	403	216	203	0.33
Хөвсгөл	593	1,144	1,250	1,547	1609	965	701	660	382	365	124	183	25	8	11	195	43	27	44	0.03
Орхон	983	1,808	1,935	1,728	1035	385	138	235	383	365	562	650	45	558	1,106	1,658	1,340	773	626	0.36
Төвийн бүс	2,763	5,488	5,536	4,857	3047	2,577	2,054	1,741	1,323	1,341	1,338	1,923	1,423	1,359	1,255	1,262	1,335	1,384	1,597	0.33
Дорноговь	299	424	335	313	206	178	182	112	379	394	320	340	348	444	351	334	451	598	404	1.29
Дундговь	382	479	407	416	551	390	84	141	57	60	39	77	62	39	41	58	105	121	57	0.14
Өмнөговь	193	531	423	329	244	318	288	265	485	472	538	193	212	119	421	534	513	425	611	1.86
Сэлэнгэ	538	937	1,151	870	405	388	704	658	147	97	275	210	367	330	152	129	45	39	23	0.03
Төв	305	1,265	953	663	384	343	320	280	87	116	14	85	57	84	115	85	52	76	62	0.09
Дархан-Уул	1,046	1,852	2,267	2,266	1246	940	420	202	96	168	140	997	347	293	59	82	136	112	402	0.18
Говьсүмбэр	-	-	-	-	11	20	56	83	72	34	12	21	30	50	116	40	33	13	38	-
Зүүн бүс	1,614	2,378	2,343	1,978	1454	1,373	1,254	894	923	861	1,188	1,118	1,185	618	558	764	783	852	604	0.31
Дорнод	1,061	1,187	1,223	1,203	765	722	608	579	414	491	503	430	683	285	173	339	375	419	318	0.26
Сүхбаатар	197	234	363	183	157	159	117	91	53	84	61	59	42	56	53	73	85	169	76	0.42
Хэнтий	356	957	757	592	532	492	529	224	456	286	624	629	460	277	332	352	323	264	210	0.35
Улаанбаатар	8,265	13,991	15,451	13,526	9851	9,130	9,834	4,159	7,241	5,339	4,778	7,243	6,358	8,214	13,895	11,900	13,164	13,805	12,661	0.94
Улаанбаатар	8,265	13,991	15,451	13,526	9851	9,130	9,834	4,159	7,241	5,339	4,778	7,243	6,358	8,214	13,895	11,900	13,164	13,805	12,661	0.94

Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам